



СЭЛЭНГЭ АЙМАГ
САНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 10 сарын 18 өдөр

Дугаар

А/122

Цагаантолгой

Шүлхий өвчнөөс сэргийлэх яаралтай
дархлаажуулалтын ажлыг зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 59.1.11, “Мал амьтны эрүүл мэндийн тухай” хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4, 9.5, 9.6, 9.7, 9.8, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 60 дугаар зүйлийн 60.2.8 дахь заалт, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2022 оны А/191 тоот тушаал, аймгийн Засаг даргын 2022 оны 9 дүгээр сарын 13-ны өдрийн “Гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх яаралтай дархлаажуулалтыг зохион байгуулах тухай” А/388 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын нутаг дэвсгэрийн хэмжээнд мал амьтны гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх яаралтай дархлаажуулалтын ажлыг 2022 оны 10 дугаар сарын 07 -ны өдрөөс 2022 оны 10 дугаар сарын 28-ны өдөр хүртэлх хугацаанд зохион байгуулсугай.

2. Дархлаажуулалтын арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай

Ажлын хэсгийн ахлагч : А.Одхүү - (Засаг даргын Тамгын газрын дарга)

Гишүүдэд- Г.Анхбаяр – (Мал эмнэлгийн тасгийн тархвар зүйч)

Б.Золбаяр -(Хушаат багийн Засаг дарга)

Л.Сэлэнгэсайхан- (Ивэн багийн Засаг дарга)

О.Лхагвасүрэн- (Сант баян хайрхан МЭҮН-н захирал)

Ө.Ганбаатар- (Бошгын булаг ХХК-ны захирал)

3. Ажлын хэсэгт ДААЛГАХ нь:

а/ Мал, амьтны гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх, дархлаажуулах үйл ажиллагаанд ААНБ, малчин, мал бүхий өрхийн 2021 оны жилийн эцсийн мал тооллогод хамрагдсан үхэр, гахайг бүрэн хамруулах

б/ Дархлаажуулалтын явцад мал амьтны шилжилт хөдөлгөөнд тавих хяналтыг сайжруулах

в/ Дархлаажуулах ажлаас малаа хоцроосон, зайлсхийсэн аж ахуй нэгж байгууллага, иргэд, хариуцлагагүй хандсан албан тушаалтанд хуулийн дагуу арга хэмжээ авч хариуцлага тооцох

г/ Дархлаажуулалтын товлосон хугацаанд мал, амьтныг бэлэн байлгаж бэхлэх, мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх нөхцөл бүрдүүлж, малын эмчийн аюулгүй байдлыг бүрэн хангах

д/ Энэ арга хэмжээний зорилго ач холбогдол хор хохирлын талаар ухуулга сурталчилгаа зохион байгуулах

е/ Арга хэмжээг товлот хугацаанд чанартай хийж, урьдчилан сэргийлэх арга хэмжээний тайланг гарган санхүүжилтийн материалыг бүрдүүлэн сумын Засаг даргаар батлуулж аймгийн Мал эмнэлгийн тасагт хүргүүлэх

4. Дархлаажуулалтын ажилд зарцуулагдах 1 (нэг) сая төгрөгийг малын тоо толгойн албан татварын орлогоос санхүүжүүлэхийг Санхүү албаны дарга (Г. Ууганцэцэг)-д үүрэг болгосугай.

5. Энэхүү захирамжийн биелэлтэд хяналт ажиллахыг сумын Засаг даргын орлогч (Б. Мөнхэрдэнэ)-д үүрэг болгосугай.



С. ШИЖИРБААТАР

Боловсруулсан: Т. Атабаев
Хянасан: Ч. Озхондор
Хувь: 2